


Хичээл №5

Балар эртний, Сонгодог, Орчин үеийн европын үндэстнүүдийн уламжлалт хувцас

(Europe: Prehistoric Europe, Classical Europe, The European folk Tradition)

Утгын сүлжээ – 8

“Балар эртний хүмүүсийн хувцасыг сэргээн төсөөлөх нь”



Чулуун зэвсгийн үеийн хүмүүсийн хад чулуун дээр зурж, бидэнд шпаргалка болгон үлдээсэн захидалууд, мөн тэдний булшнаас илэрсэн дурсгалууд, орчин үеийн сэтгэл судлалын онолын материал, дизайнеруудын зохион бүтээсэн загварын зургуудыг ашиглаж, *“Балар эртний хүмүүсийн хувцасыг сэргээн төсөөлөх нь”* утгын сүлжээтэй ажиллаарай.

Түлхүүр үгс: Испани, Франц, Зигмунд Фройд, Натуф соёл, орчин үеийн загвар.

Европын сонгодог үе

Утгын сүлжээ – 9



Хөтөч үг:

- Эртний Грекийн гайхамшигт соёл урлаг Эгейн тэнгис, Газрын дундад тэнгисийн сав газрын хот улсуудын ялангуяа, Крит, Микений соёлын суурин дээр хөгжсөн гэдгийг санах хэрэгтэй. Крит арлын гол хот болох Кносс хотын ордны ханыг байглийн элдэв амьтан, ургамал, хүмүүсийн олон янзын үйл хөдлөлийг харуулсан маш баялаг өнгө, хөдөлгөөнтэй дүрсээр чимсэн байдаг нь бидэнд НТӨ III-II мянган жилийн өмнөх Крит арлын оршин суугчдын хувцасны дүр төрхийг олж харах боломжийг олгодог.

- Харин НТӨ XV-XII зууны үед цэцэглэж байсан, Крит арлын Минионы соёлын уламжлалыг хөгжүүлсэн Микений ваар, фреска, алтан эдлэлүүдэд дүрслэгдэн үлдсэн байгаль, шашин шүтлэг, ав, дайн тулааныг үзүүлсэн дүрслэлүүдээс Микений хувцасны загварыг харах боломжтой.

Энэ бүх эх сурвалжууд Грекийн урлаг сонгодог хэлбэрээр хөгжих хөрс суурь болсон бол Ромын хувцас нь Этруссийн хувцасны суурин дээр хөгжсөн гэдэг.

Орчин үеийн европын үндэстнүүдийн уламжлалт хувцас

Утгын сүлжээ – 9



ДААЛГВАР

1. Орчин үеийн Европын олон улс орны үндэстэн угсаатнуудын уламжлалт хувцаснуудыг судалж, утгын сүлжээний зургуудыг ямар ямар үндэстнийх болохыг ялгаж ойлгоод,
2. Сэргэн мандалтын үеийн хувцасны ялгааг судлах “Утгын сүлжээ” зохиож ирүүлээрэй !